0.1 Улсын шалгалтын бүртгэх дараалал

Улсын шалгалтын бүртгэл

Шалгалтын дүн бүртгэх хугацаа:

УЛСЫН ШАЛГАЛТ:
1. Бүх улсын шалгалтын дүнг шалгалт болсон өдрийн 11:00 цагаас бүртгэж эхлэх боломжтой.
2. Шалгалтын дүнг шалгалт дууссанаас хойш 24 цагийн дараа өдрийн 11:59 цагаас өмнө бүртгэж дуусгана.

Шалгалтын дүнгийн мэдээллийг системд дараах дарааллыг баримтлан оруулна.


1. Улсын шалгалтанд шалгуулагч бүртгэх, үнэлгээ бүртгэх болон үнэлгээ илгээх боломж нь тухайн төгсөх ангийн анги удирдсан багшийн es35....,es40.....-той багшийн эрхээр бүртгэл хийнэ.

2. Анги удирдсан багш ES35.....,ES40..... -тай эрхээр нэвтэрч зөвхөн хариуцсан ангийн суралцагчийг шалгалтанд бүртгэх боломжтой. Хэрэв тухайн шалгалтанд орох ёсгүй суралцагчийг бүртгэсэн бол <u>үйлдэл</u> дотроос <u>шалгалт өгөгч</u> хасах үйлдлээр хасна.

3. Анги удирдсан багш нь зөвхөн хариуцсан анги бүлгийн суралцагчдийн улсын шалгалтын ирц, үнэлгээг бүртгэж хадгална.

4. **<u>Улсын шалгалт:</u>** Анги удирдсан багш нь шалгалт өгсөн анги бүлгийн суралцагч нэг бүрийн шалгалтын дүнг бүрэн оруулсны дараа баталгаажуулах хүсэлт илгээж харъяа БСУГ -т баталгаажуулалт үйлдлийг хийнэ.

УЛСЫН ШАЛГАЛТЫН ПРОЦЕСС



1. Анги удирдсан багш: Суралцагчийг хуваарьт улсын шалгалтанд бүртгэнэ.
2. Анги удирдсан багш: Шалгалт явагдаж дууссаны дараа суралцагчийн дүнг бүртгэнэ.
3. Баталгаажуулах хүсэлт илгээсэн бол харьяа БСУГ -т шалгалтын дүн баталгаажуулах хүсэлт илгээнэ.
4. БСУГ: Тухайн улсын шалгалт өгсөн суралцагчдын бүртгэлийг дүнгийн хамт хүлээн авна.
5. БСУГ: Шалгалтын дүнг хянана.

5.1 БСУГ: Буруу эсвэл алдаатай гэж үзвэл суралцагчийн хичээлийн дүнг буцааж болно. Дүн нь "Цуцлагдсан" төлөвт шилжинэ.

5.2 БСУГ: Дүнг хянаад зөвшөөрч байвал Баталгаажуулалт хийнэ.

6. Сургуулийн шалгалтын комисс: Шалгалтын дүнгийн нэгтгэл хүлээн авна.